



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/413

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2229, Их Монгол улс байгуулагдсны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн Үндэсний их баяр наадамьн урианхай сурын харвааны төрөлд тэргүүн байр эзлэн “Улсын мэргэн” цол хүртсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, “Гүрт бүрд” ХХК-ны харваач Эрхэмбаярын Хосбаярт хүндэтгэл үзүүлэх зардалд 350000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний зардалд зарцуулах 350000 төгрөг /Гурван зуун тавин мянган/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.17 дахь “Спортын аварга” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

9

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 31-ний өдрийн
А/413 дугаар захирамжийн хавсралт

“УЛСЫН МЭРГЭН” ЦОЛ ХҮРТСЭН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗАР, СУМ ДУНДЫН ОЙН АНГИ, ГҮРТ БҮРД ХХК-НИЙ ХАРВААЧ
ЭРХЭМБАЯРЫН ХОСБАЯРТ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Овог нэр	Шангал	Нийт үнэ
1	Эрхэмбаярын Хосбаяр	350 000	350 000
	Дүн		350 000

-oOo-